



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/151

Сангийндалай


Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/15 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан улсын нөөцөөс 50 хувийн хямдралтай үнээр суманд хуваарилсан 1390 боодол өвс, 600 шуудай тэжээлийн үнэ 14,494,500 (арван дөрвөн сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга таван зуу) төгрөгийг аймгийн Онцгой байдлын газрын 100900031005 тоот дансанд төвлөрүүлэхийг Засаг даргын тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр), нягтлан бодогч (Ж.Хишигсүрэн) нарт зөвшөөрсүгэй.

2. Хямдралтай өвс, тэжээлийг татан авч, хуваарилж, малчдад хүргэх ажлыг шуурхай зохион байгуулахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Г.Энхдэлгэр), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



О.БАЗАРРАГЧАА.

482302101